

Ерөнхий боловсролын Шинэ Монгол Гурав
сургуулийн захирлын 2026 оны 04 сарын 30-ны
өдрийн А/06 дугаар тушаалын хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ШИНЭ МОНГОЛ ГУРАВ СУРГУУЛИЙН
3-5 ДУГААР АНГИД ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 2026-2027 оны хичээлийн жилд тус сургуулийн 3-5 дугаар ангийн элсэлтийг зохион байгуулах явцад үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2 3-5-р ангийн элсэлтийн шалгалтыг Монгол хэл, Математикийн хичээлээр бага боловсролын цөм хөтөлбөрийн агуулгаар танхимд зохион байгуулна.
- 1.3 Шалгалтын дүнгээр 3-5-р ангид нийт 90 сурагч (анги тус бүр 30) элсүүлэх ба нийт элсэгчдийн 70 хувийн квотыг Неосити хотхоны оршин суугчдад нээлттэй зарлана.

ХОЁР. БҮРТГЭЛ

- 2.1 Бүртгэл 2026 оны 05 дугаар сарын 04-ны 11:00 цагаас 05 дугаар сарын 21-ний 16:00 цаг хүртэл <https://shinemongol3.edu.mn/admission> хаягаар бүртгүүлнэ.
- 2.2 Бүртгүүлэхэд тавигдах шаардлага, анхаарах зүйлс:
 - a. Бүртгүүлэгч нь анги алгасах буюу ухран суралцахгүй бөгөөд Боловсролын байгууллагын мэдээллийн систем болох ESIS системд бүртгэлтэй ангийн дагуу бүртгүүлнэ;
 - b. Бүртгүүлэгчийн овог, нэрийг кирилл үсгээр бичиж, регистрийн дугаарыг алдаагүй зөв оруулна. Цахим бүртгэлд нэг л удаа бүртгүүлэх боломжтой байна;
 - c. Бүртгүүлэгч хүүхдийн сүүлийн 3 сарын дотор авахуулсан цээж зургийг регистрийн дугаараар нь нэрлэн, jpeg, png, jpg өргөтгөлийн аль нэгээр хадгалсан файлыг системд оруулах;
 - d. Бүртгүүлэгчийн эцэг эх, асран хамгаалагч нь өөрийн и-мэйл хаяг, холбоо барих утасны дугаарыг алдаагүй зөв бичих;
- 2.3 Хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч болон элсэгч доорх асуултад дэлгэрэнгүй хариулж, word, pdf файлаар эсвэл гараар тод, гаргацтай бичиж зураг хэлбэрээр буюу jpeg, png, jpg өргөтгөлийн аль нэгээр оруулна. Асуултын хариултыг сургуульд хүүхдээ оруулах чин хүсэлтэй эсэхийг харгалзах, хүүхдийн оноо тэнцсэн тохиолдолд шийдвэрлэх зорилгоор хүлээн авч байгаа болно.

Асуулт 1: Танай гэр бүл яагаад Шинэ Монгол Гурав сургуулийг сонгож байгаа вэ?

Асуулт 2: Таны хүүхдийн онцлог, давуу чанар юу вэ? Цаашид хүүхдийнхээ ямар чанарыг хөгжүүлэхийг хүсэж байна вэ?
- 2.4 Бүртгэлийн хураамж 40.000 (дөчин мянга) төгрөгийг зааврын дагуу төлснөөр бүртгэл баталгаажин, цахим бүртгэлийн системд нэвтэрч шалгалттай холбоотой аливаа мэдээллийг

авах эрх үүснэ. Бүртгүүлэгчийн элсэлтийн шалгалтад орсон эсэхээс үл хамааран бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй.

2.5 Бүртгүүлэгч доорх мэдээллийг 2026 оны 05 дугаар сарын 23-ны 12:00 цагаас хойш бүртгэлийн системээс харах боломжтой болно.

- a. Бүртгэлийн дугаар
- b. Шалгалтын цагийн хуваарь
- c. Шалгалт өгөх танхим, суудлын дугаар

Жич: Дээрх мэдээллийг бүртгүүлсэн и-мэйлээр хүргэнэ.

ГУРАВ. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

3.1 3-5-р ангийн элсэлтийн шалгалтыг 2026 оны 05 дугаар сарын 24-нд 14:00 цагт Шинэ Монгол Гурав сургуулийн байранд танхимаар зохион байгуулна. Үүнд:

3-р ангид: Монгол хэл-50% (20 мин), Математик-50% (20 мин)

4-р ангид: Монгол хэл-50% (40 мин), Математик-50% (40 мин)

5-р ангид: Монгол хэл-50% (40 мин), Математик-50% (40 мин)

3.2 Шалгалтын явц

3.2.1 Шалгалтын сэдэв боловсруулах багийг томилох, нууцлалыг хадгалан ажиллах үүргийг элсэлтийн комисс хариуцна.

3.2.2 Шалгалтын сэдвийг тухайн хичээлүүдийн бага боловсролын цөм хөтөлбөрийн үндсэн агуулгын хүрээнд боловсруулна.

3.2.3 Элсэлтийн комисс шалгалтын сэдвийг шалгалт эхлэхээс нэг цагийн өмнө шалгуулагчдын тоогоор хувилж бэлтгэнэ.

3.2.4 Шалгалтын сэдэв тараагдсанаас хойш хоцорсон сурагчдыг огт оруулахгүй байх ба хоцорсон тохиолдол дахин шалгалтыг авахгүй тул заасан хугацаанаас хоцрохгүй байх. Хоцорсон сурагчдыг шалгалт өгүүлэх тухай хүсэлтийг хүлээж авахгүй.

3.2.5 Хянагч багш шалгалтын дэгийг уншиж танилцуулна.

3.2.6 Хянагч багш шалгалтын материалыг тарааж, шалгалтыг эхлүүлнэ.

3.2.7 Шалгалтын хугацаа дуусмагц хянагч багш шалгуулагчдын материалыг болон гар бичмэлийг /ноорог/ хурааж авна.

3.2.8 Шалгалтын явцад шалгуулагч нь дэг зөрчвөл шалгалтаас шууд чөлөөлнө.

3.2.9 Шалгалтын материалыг томилогдсон багш засаж, шалгалтын хуудас болон оноог комисст хүлээлгэн өгнө.

ДӨРӨВ. ДҮН ТАНИЛЦУУЛАХ

4.1 Шалгалтын дүн мэдээ, элсэх эрх олгосон тухай нэгдсэн мэдээллийг 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 12:00 цагт бүртгэлийн системд болон “[Шинэ Монгол-3 сургууль](#)” фэйсбүүк хуудсанд байршуулна.

ТАВ. ЭЛСЭЛТИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ

- 5.1 Шалгалтад тэнцсэн элсэгчдэд 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр бүртгэлийн систем болон “Шинэ Монгол-3 сургууль” фэйсбүүк хуудаст байршуулсан хуваарийн дагуу ирж батламжаа гардан авна.
- 5.2 Элсэх болзол хангаж батламж гардан авсан элсэгчид сургалтын төлбөрөө бүрэн төлж барагдуулсны үндсэн дээр, Шинэ Монгол Гурав сургуулийн хичээлийн байранд ирж сургууль болон эцэг эх/ асран хамгаалагчийн хамтран ажиллах гэрээг байгуулснаар суудал баталгаажна.
- 5.3 Бага ангид элсэн суралцах суралцагчдын эцэг эх/асран хамгаалагч 2026 оны 05 дугаар сарын 28-наас 06 дугаар сарын 05-ний хугацаанд ажлын өдрүүдэд сургууль болон эцэг эх/ асран хамгаалагчийн хамтран ажиллах гэрээг байгуулна.
- 5.4 Элсэлт баталгаажуулахаар ирэхдээ доорх материалуудыг бүрэн авч ирнэ. Үүнд:
- Сурагчийн хувийн хэрэг (шилжүүлэг хийлгэсэн байх) Гадаадаас шилжин ирж байгаа бол сурагчийн хувийн хэрэгтэй дүйцэх боловсролын бичиг баримт
 - Төрсний гэрчилгээний хуулбар
 - Сурагчийн эцэг эхийн иргэний үнэмлэхийн хуулбар
 - Төлбөр төлсөн баримт /Жилийн төлбөр 10,5 сая төгрөг/
- 5.5 Зарласан хугацаанд ирж гэрээ байгуулаагүй тохиолдолд тус сургуульд элсэхээс татгалзсан гэж үзэн онооны дарааллаар дараагийн шалгуулагчид элсэх эрхийг шилжүүлнэ.
- 5.6 Элсэлтийн үйл ажиллагаанд холбогдох аливаа маргаан, зөрчлийг шалгалтын дүн гарснаас хойш ажлын 3 өдөрт бичгээр хүлээн авч, өргөдлийг хүлээж авснаас хойш ажлын 3 өдөрт шийдвэрлэнэ.

ЗУРГАА. БУСАД

- 6.1 Цахим бүртгэлтэй холбоотой тодруулах зүйлийг 10:00-17:00 цагийн хооронд 85991003 дугаарт холбогдож зөвлөгөөг авч болно.
- 6.2 Шалгалтын талаарх санал хүсэлтийг 2026 оны 05-р сарын 28-ны өдрийн 16:00 цаг хүртэл hello@shinemongol3.edu.mn и-мэйл хаягаар хүлээн авна.

ЭЛСЭЛТИЙН КОМИСС